

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС
2019 ОНЫ 07 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 07 дугаар сарын 29

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 07 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 2999 ширхгийг шинээр хэвлэн, 2362 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 80 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын есөн иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 2800 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 4989 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1992, 7585-1882 дугаарын утсаар 285, биечлэн 821, автомат хариулагчаар 1891 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Канад Улсын Оттава, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Дели хот дахь консулын ажилтан нарт утсаар виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, 19 улсын 23 гадаадын иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээрээс “J” ангиллын 102, “B” ангиллын 109 визийн зөвшөөрөл, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 163 визийн зөвшөөрөл, нийт давхардсан тоогоор 518 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 404 аж ахуйн нэгж, байгууллагын 1092 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 217 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 25 иргэнд визийн зөвшөөрөл, 68 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 116 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 22 иргэний ангиллыг сольж, 18 иргэнд бүртгэл, 13 иргэнд хаягийн өөрчлөлт, 14 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 149 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 07 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 19.9 хувиар, виз олголт 17.6 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 22.8 хувиар, түр ирэгчийн бүртгэл 6.9 хувиар өссөн, харин хувийн урилга олголт 29.5 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 8.9 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 19.4 хувиар, түр ирэгчийн хасалт 3.4 хувиар, визийн сунгалт 24.6 хувиар тус тус буурсан байна.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй гурван хүний хүсэлтийг шинээр хүлээн авсан ба байгууллагын даргын 2016 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу Оросын Холбооны Улсын нэг иргэн, харьяалалгүй нэг хүнтэй ярилцлага хийсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, харьяалалгүй нэг хүний хүсэлтийг шийдвэрлүүлэхээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлээ.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоёр удаагийн зарлигаар нэг улсын дөрвөн иргэн, харьяалалгүй хоёр хүн Монгол Улсын харьяат болсон байна.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын найман улсын харьяат болох хүсэлт гаргасан 54 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 73 иргэний хүсэлтэд холбогдох газраас санал авах ажиллагааг хийсэн.

Мөн Монгол Улсын харьяатаас гарч гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 36 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.


Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоёр удаагийн зарлигаар 40 иргэн Монгол Улсын харьяатаас гарчээ.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй гурван хүний хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг

эхлүүлсэн. Мөн харьяалалгүй гурван хүний баримт бичгийг хянан холбогдох газраас санал авах ажиллагааг хийсэн байна.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй таван хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 124 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3293 иргэн бүртгэлтэй байна.



Мэргэжлийн зөвлөлийн хурлаар есөн төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгалаа. Түүнчлэн дээрх хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан гурван олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 07 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 95 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэх хүсэлт гаргасан гадаад улсын нэг гэр бүлтэй ярилцлага хийж, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр Монгол Улсын харьяат нэг хүүхдийг байгууллагын даргын тушаалаар үрчлүүлж, үрчлэлтийн дараа хяналт тавих гурван талт гэрээг байгуулсан.

2005-2012 онд “Холт интернэшнл” хүүхдийн төлөө олон улсын байгууллагаар зуучлуулан Америкийн Нэгдсэн Улсын гурван гэр бүлд үрчлэгдсэн долоон хүүхдийг эх орныхоо өв соёл, зан заншилтай танилцах арга хэмжээг зохион байгууллаа.


1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн таван улсын 56 иргэнийг байгууллагын даргын 13 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын таван удаагийн тушаалаар гадаадын гурван улсын зургаан иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, хоёр удаагийн тушаалаар гадаадын хоёр улсын хоёр иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 155 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг үндэслэн хоёр аж ахуйн нэгжид хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд найман удаагийн төлөвлөгөөт, 17 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 114 аж ахуйн нэгж, байгууллага, 1960 гадаадын иргэнийг хамруулсан ба 231 гадаадын иргэн, 156 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 383 иргэн/, долоон уригч иргэн /гадаадын найман иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 115,690,000 /нэг зуун арван таван сая зургаан зуун ерэн мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээ.



2019 оны 07 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 11.1 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 2.3 дахин, албадан гаргагдсан гадаадын иргэн 2.8 дахин, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 50 хувиар тус тус өссөн, харин зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 3.1 хувиар буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлж буй “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 06 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн хэрэгжилт, байгууллагын 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад, байгууллагын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилт, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гадаадын иргэн,

харьяатын газрын 2019 оны эхний хагас жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанд тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Байгууллагын эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 62 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэсэн бөгөөд хэрэгжилт 86.7 хувьтай байна.

Байгууллагын 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг сэтгүүл хэлбэрээр эмхэтгэн 21 ширхгийг хэвлүүлэн, холбогдох нэгж, албан хаагчдад хүргэлээ. Мөн байгууллагын эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангийн хурлыг зохион байгуулан ажиллав.

2019 оны байгууллагын даргын 01-03/13 дугаар удирдамжийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газрын үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийж, шалгалтын дүн болон шалгалтын бүрэлдэхүүнээс өгсөн санал, дүгнэлтийг нэгтгэн ажиллалаа.

Архивын тухай хуулийн 10.1.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд 2003-2014 оны байнга хадгалах хадгаламжийн нэгжүүдийг бэлтгэн, Үндэсний төв архивт шилжүүлэхэд бэлэн болгосон ба Үндэсний төв архивын газраас 08 дугаар сард уг баримтыг хүлээн авахаар болсон.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 61 өргөдөл, нэг гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 55 өргөдөл, нэг гомдол шийдвэрлэгдэж, зургаан өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон тав, мэргэшлийн зэрэг шинээр тогтоолгосон зургаан албан хаагчид 10-20 хувийн цалингийн нэмэгдлийг байгууллагын даргын тушаалаар олгож эхэлсэн.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2019 оны эхний хагас жилийн тайлан, төлөвлөгөөний биелэлт, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэл, өргөдөл гомдлын судалгааг Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлэв.

Тулгар төрийн 2228, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар нэг албан хаагч “Цэргийн хүндэт медаль”-аар, хоёр албан хаагч “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, долоон албан хаагч Хууль зүй, дотоод хэргийн яамны жуух бичгээр, есөн албан хаагч байгууллагын “Хүндэт өргөмжлөл” тус тус шагнагдлаа.

Байгууллагын даргын 2019 оны А/207 дугаар тушаалын дагуу байгууллагын төв болон орон нутаг дахь газрын ахлах нягтлан бодогч, нярав нарт зориулсан “Төсөв, санхүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 20 албан хаагч хамрагдсан бөгөөд төсөв, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн долоон байгууллагаас сургалтыг орсон.

Албан хаагчдын мэдээллийн цагаар Дотоод хэргийн их сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, доктор С.Гантулгыг урьж “Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн талаар сургалт зохион байгуулж,

сургалтад төвийн 47, орон нутаг дахь газрын 43 албан хаагч цахим сүлжээгээр хамрагдлаа.

Мөн “Гадаадын иргэдийн визийн зөвшөөрөл, төрөл, ангилал, шаардлага, бүрдүүлэх материал, хууль тогтоомж, цаашдын чиг хандлага” сэдвээр “Эрнст энд Янг ТМЗ” ХХК-ны албан хаагчдад сургалт, Гадаад харилцааны яамны Консулын газраас гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, консулын газарт томилогдсон нийт 33 албан хаагчдад гадаадын иргэний виз, бүртгэлийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дадлага хийлгэв.

Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл-оролцоо” сургалт, хэлэлцүүлэгт нэг албан хаагч, Турк Улсын Үндэстний цагдаагийн академи, Дотоод хэргийн их сургуулиас хамтран зохион байгуулсан “Хүн худалдаалах болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” чиглэлийн сургагч багш бэлтгэх сертификаттай сургалтад хоёр албан хаагч, Бүгд Найрамдах Тажикстан Улсын Душамбе хот дахь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хилийн менежментийн коллежид зохион байгуулагдсан “Эмэгтэй удирдах албан тушаалтнуудын 24 дэх удаагийн сургалт”-д /сертификаттай/ нэг албан хаагч тус тус хамрагдлаа. Түүнчлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын “Бээжингийн гадаад хэлний сургууль”-д 2018 оны 09 дүгээр сараас 2019 оны 07 дугаар сарын хооронд зохион байгуулагдсан “13 дугаар Олон улсын хууль сахиулагч харилцааны албан хаагчдын хөтөлбөр”-т нэг албан хаагч хамрагдаж төгссөн.

Америкийн Нэгдсэн Улсын гурван гэр бүлд үрчлэгдсэн долоон хүүхдийг эх орныхоо өв соёл, зан заншилтай танилцах арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээний мэдээ, сурвалжилгыг 10 телевиз, гурван сонин, есөн цахим хуудас, нэг радиогоор олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Мөн Бүгд Найрамдах Турк Улсын харьяат найман багш Монгол Улсад оршин суух тухай үүссэн нөхцөл байдлын асуудалтай холбогдуулан холбогдох албан тушаалтан “Ublife” цахим хуудаст тайлбар ярилцлага өгсөн бөгөөд уг мэдээлэл “gogo.mn” цахим хуудаст эх сурвалжтайгаар нийтлэгдсэн болно.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 07 дугаар сарын 02-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр хуулийн төслийг эцсийн байдлаар хянан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга болон тус яамны мэргэжилтэн цахим шуудангаар [/altantuya.b@mojha.gov.mn/](mailto:altantuya.b@mojha.gov.mn) 07 дугаар сарын 08-ны өдөр хүргүүлж ажиллав.

Тайлангийн хугацаанд тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд шинээр томилогдохоор нэр дэвшсэн дөрөв, шилжин томилогдохоор нэр дэвшсэн хоёр, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн дөрөв, нийт 10 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, шинээр томилогдсон 13, их хэмжээний

өөрчлөлтөө мэдүүлсэн хоёр, нийт 15 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажууллаа.

Байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэд консул Кил Кан Мугийг байгууллагадаа хүлээн авч уулзан цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Түүнчлэн байгууллагын даргын урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг Аюулаас Хамгаалах яамны Цагаачлалын удирдах газрын дэд дарга Жио Чан Хуа тэргүүтэй төлөөлөгчид тус байгууллагад 2019 оны 08 дугаар сарын 02-оос 04-ний өдрүүдэд, Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албаны дарга Ча Гү Гюүн тэргүүтэй төлөөлөгчид тус байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй танилцахаар 2019 оны 08 дугаар сарын 19-өөс 23-ны өдрүүдэд албан айлчлал хийхтэй холбогдуулан айлчлалын бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Цахим шалгалтын программ хангамж дээр сургалтын зар, хичээл заасан сургалтын материалыг байршуулах нэмэлт модулийн хөгжүүлэлтийг хийж, ашиглалтад орууллаа. Мөн шинээр ашиглалтад оруулсан өргөдөл, гомдлын программд өмнө ашиглагдаж байсан өгөгдлийн санг хөрвүүлэх ажлыг бүрэн хийж дуусгав.

“E-Visa” цахим системийн хөгжүүлэлтийн хүрээнд хоёр удаагийн 17 өөрчлөлт, шинэчлэлтийг программд оруулан, цахимаар ирүүлсэн визийн хүсэлтийг цаасан хэлбэрээр танилцуулдаг байсныг цахимаар хянаж, шийдвэрлэх боломж бүхий нэмэлт хөгжүүлэлтийг хийж ашиглалтад орууллаа.

2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6.27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 07 дугаар сард 3.97 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 3.41 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2019 оны 07 дугаар сарын байдлаар 3 тэрбум 341 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 633,2 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тайлбар тодруулгыг 02/1365 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Нормын гутал нийлүүлсэн “Хос-Аз” ХХК-тай гэрээ дүгнэсэн акт үйлдэн тооцоо нийлж, үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Орон нутаг дахь газрын албан хаагчдад захтай цамц, хээрийн хувцас, тэлээ, богино хүрэм зэрэг 2019 оны нормын хувцасны хангалтыг хийлээ.

Мөн орон нутаг дахь албанд шаардлагатай компьютер тоног төхөөрөмж болох 22 ширхэг компьютер, есөн ширхэг гурван үйлдэлт принтер, таван ширхэг гадна камер, 10 ширхэг дотор камер, хоёр ширхэг бичигч, хоёр ширхэг сүлжээний свичийг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газраас хүлээн авсан.

Байгууллагын албан хаагчдын хүүхдийн цэцэрлэг байгуулахтай холбогдуулан “Дөрвөн шар” ХХК-аар 648 м.кв хана, таазанд замаск, эмульс хийлгэж, 252 м.кв паркетан шал, 216 метр шалны хүрээ суулгуулж, 68 метр цахилгааны утас шинээр татан, 73 ширхэг гэрэл шинээр суулгуулан, ахлах, дунд, бага ангийн өрөөнүүдэд өнгөт хавтангаар хана, хаалга хийлгүүлсэн. Түүнчлэн “Мандах цацрал” ХХК-аар 25 м.кв вакуум цонх, хаалга нэг ширхгийг суулгуулан, иргэн А.Батмөнхтэй №2019/0717 дугаар гэрээ байгуулан 12 ширхэг хүүхдийн жорлон, 12 ширхэг угаалтуур суулгуулан, цэцэрлэгийн гал тогооны өрөөнд цэвэр, бохир усны шугам хоолой татуулах ажлыг зохион байгуулсан бөгөөд засварын ажил дууссаны дараагаар нийт албан хаагчдыг хамруулан их цэвэрлэгээг хийлээ.

2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 06 дугаар сарын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, мөн сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт, 2019 оны эхний хагас жилийн танилцуулах тойм мэдээ, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газрын 2019 оны хоёрдугаар улирлын мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлсэн. Мөн статистикийг дэмжих тухай улс орны тайланг гаргахад шаардлагатай асуулгын хуудсыг Үндэсний статистикийн хорооны гаргасан аргачлалын дагуу нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Байгууллагад 2019 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, эхний хагас жилийн байгууллагын даргын тушаал, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, байгууллагын 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн ажиллав.

Байгууллагын даргын 2019 оны 01-09/15 дугаар удирдамжийн дагуу хоёрдугаар улирлын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх талаар хяналт-шинжилгээ хийж, ажлын тайланг 02/1346 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Шилэн дансны тухай хуулийн хоёрдугаар улирлын хэрэгжилт тоон үзүүлэлт өссөн дүнгээр 99.2 хувьтай байна.

2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 73 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 22 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг 229 гадаадын иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Буянт-Ухаа боомт дахь Агаарын замын боомт хариуцсан газраас “Дэлхийн хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх өдөр”-ийг тохиолдуулан “Чингис хаан” олон улсын нисэх буудалд зохион байгуулсан өдөрлөг, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлын нээлтийн ажиллагаанд оролцож, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа.

“Торгоны зам-2019” авто ралли уралдаанд оролцогч тамирчид болон арын албаны бүрэлдэхүүн нийт 1752 гадаадын иргэн Алтанбулаг авто замын боомт, Өмнөговь аймгийн Ханбумбат нисэх буудал, Гашуунсухайт авто замын боомтоор тус тус улсын хил нэвтэрсэн бөгөөд гадаадын иргэний виз, бүртгэлтэй холбоотой ямар нэгэн зөрчил, хүндрэл үүсээгүй болно. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны 21 дүгээр захирамжаар байгуулагдсан уралдаанд оролцогчид, дагалдан ажиллагсдыг Монгол Улсын хилийн боомтоор нэвтрүүлэх болон гарах асуудал хариуцсан дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байгууллагын дарга болон холбогдох албан хаагчид Өмнөговь аймгийн Даланзадгад хот, Гашуунсухайт авто замын боомтод ажиллаж, дүнг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргад 02/1380 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Түүнчлэн давхардсан тоогоор дотооддоо зохион байгуулсан долоон удаагийн сургалтад 142 албан хаагч, бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан хоёр удаагийн сургалтад 23 албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан долоон удаагийн сургалт, зөвлөгөөнд 55 албан хаагч, нийт 220 албан хаагч тус тус хамрагдсан байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР